



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

№94 /538/

2023.06.12

Цаг үе, үйл явдал

## БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД ЗАВХАН АЙМАГТ АЖИЛЛАЛАА



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба болон БХЯ, ЗХЖШ-ын удирдлагууд Завхан аймагт ажиллалаа. Батлан хамгаалахын сайдыг хүрэлцэн ирэхэд Улиастай цэргийн хүрээний хүндэт харуул жагсаж, ёслол төгөлдөр угтлаа.

Үргэлжлүүлэн Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн захирагч хурандаа Б.Баярсайхан ангийнхаа түүх, үйл ажиллагаа, дэвшүүлсэн зорилго зорилт, тулгамдсан асуудлуудаа танилцуулав.

Анги хуулиар хүлээсэн үндсэн үүргээ гүйцэтгэхийн зэрэгцээ офицер, ахлагч, ажилтан албан хаагчдынхаа ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан ангийн байрлал дахь объектуудын засвар, тохижилтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн талаар илтгэсэн юм.

Мөн тус аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх хүрээнд хамтарсан сургууль дадлага, урлаг спортын тэмцээн уралдааныг тогтмол зохион байгуулдаггаа онцлов.

Үүний дараа Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр салбаруудын бие бүрэлдэхүүнтэй уулзаж, Засгийн газрын үйл ажиллагаа, Батлан хамгаалах бодлого, зорилтын талаар танилцуулав. Тэрбээр "Алсын хараа 2050" болон "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэхэд Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үүрэг оролцоо өндөр байгааг онцоллоо. Түүнчлэн Батлан хамгаалахын эрх зүйн шинэчлэл, Зэвсэгт хүчний ирэх зууны өнгө төрх сайд, удирдлагуудаас гадна Зэвсэгт хүчинд алба хааж байгаа хүн нэг бүрээс хамааралтай гэдгийг онцлоод цаашид эрхэлсэн ажилдаа эзэн болж, хандлагаа өөрчилж, хариуцлагаа

нэмэгдүүлэхийг уриалсан юм. Батлан хамгаалах, Зэвсэгт хүчин нь сүүлийн жилүүдэд хөнгөн хуягт техникүүдийг дотооддоо үйлдвэрлэж, зэвсэглэлд туршсаны зэрэгцээ бага бууны сумны үйлдвэр байгуулах болсноор бүтээн байгуулагч салбар болох үндэс суурь тавигдсаныг салбарын сайд хэллээ.

Мөн цаашид Зэвсэгт хүчин болон Агаарын цэргийн зэвсэглэл техникийг шинэчлэх, хөгжүүлэхэд тал бүрээр дэмжихээ илэрхийлж, бие бүрэлдэхүүнд ажлын өндөр амжилт, гэр бүлд нь аз жаргал эрүүл энхийг хүссэн юм.

Төгсгөлд нь Батлан хамгаалахын сайд салбаруудад тулгамдсан зарим асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэхийг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгосны зэрэгцээ олон үйлдэлт ухаалаг дэлгэц болон портер машины түлхүүрийг ангийн захирагчид гардуулан өгөв.

Дэслэгч Т.ИДЭР

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 29	🌧️ 11

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 34	🌧️ 24

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,435	3,442
EUR 🇪🇺	3,695	3,715
CNY 🇨🇳	482	485
RUB 🇷🇺	41	41.40
JPY 🇯🇵	24.90	25.05
KRW 🇰🇷	2.63	2.65

### ЗУРХАЙ

2023.06.12 /ДАВАА ГАРАГ/  
БИЛГИЙН ТООЛЛЫН 24

**ЗУНЫ ТЭРГҮҮН УЛААГЧИН  
МОГОЙ САР  
ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ  
ЦАГААГЧИН ҮХЭР ӨДӨР**

**Үс засуулбал:**  
**Өвчин эмгэг ирнэ**  
**НАРАН УРГАХ, ШИНГЭХ:**  
**04.53-20.51**  
**Барилдлага:**  
**Рашаан**  
**ШҮТЭН БАРИЛДЛАГА:**  
**САНСАР**

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Эл өдөр насны хүч дэлгэрнэ. Эм найруулах, угаал үйлдэх, бэр авах, насны авшиг, насны бүтээл хийх зан үйл хийгээд төрөл садан бололцох, худалдаа наймааны үйлнээ сайн болой, бурханы ёс ба тарни бүтээх, амраг нөхдийг хураахуйд сайн. Баруун чих хангинавал асрагдах, зүүн нь бол буян арвижих, нохой уливал гэрийн тэнгэр зайлсан, хэрээ гуаглавал эд агуурс олдох, тагнай загатнавал зочин ирэх, бие татвал гаслан болох, хөл татвал хувцас олдно.

## БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД БАЯН-ӨЛГИЙ АЙМАГТ АЖИЛЛАЛАА



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба болон БХЯ, ЗХЖШ-ын удирдлагууд Баян-Өлгий аймагт байрлах Зэвсэгт хүчний ангиудад ажиллалаа.

Батлан хамгаалахын сайдыг тус аймагт хүрэлцэн ирэхэд Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн хүндэт харуул угтан авав. Тус анги нь Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвтэй хамтран хугацаат цэргийн алба хаагчдад мэргэжил олгох сургалтыг барилгын өргөн мэргэжил, хүнд машин, механизмын оператор, засварчин зэрэг чиглэлээр зохион

байгуулсан байна. Хугацаат цэргийн алба хаагчид бүтээн байгуулалтын ажилд оролцоноор мөнгөн хуримтлал үүсгэхээс гадна мэргэжил эзэмшээд халагдах давуу талтайг ангийн захирагч хурандаа У.Буянжаргал танилцуулав. Харин Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн хувьд сүүлийн жилүүдэд ангийн бүтээн байгуулалт, бие бүрэлдхүүнийг сурган дадлагажуулах талаар гол анхаарал хандуулан ажиллаж байна. Мөн уг ангийн байрлалд уулын авиралтын спорт заалны барилгын ажил үргэлжилж буй талаар тус ангийн захирагч дэд хурандаа Х.Золжаргал уламжиллаа.

Ажлын хэсэг үргэлжлүүлэн тус ангиудын штабын байр, алдрын танхим,

эрүүл мэндийн төв, цэргийн гал тогоо, цэргийн гэрээт болон хугацаат албаны дайчдын алба хааж буй орчин нөхцөлтэй танилцаж, санал сэтгэгдлийг нь сонсов.

Мөн Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр ангиудын бие бүрэлдэхүүнтэй уулзаж Засгийн газрын үйл ажиллагаа, салбарын эрх зүйн шинэчлэл, бодлогын хэрэгжилтийн хүрээнд хийгдэж буй ажлууд, алба хаагчдын харилцаа хандлага, ёс зүйн төлөвшил, манлайлал, нийгмийн хамгааллын талаар мэдээлэл өгч, албандаа итгэл үнэмшил дүүрэн, хичээл зүтгэл өндөр байхыг онцлон дурдсан юм. Түүнчлэн хөдөлмөр, зүтгэл, албандаа хандах хандлагаараа бусдадаа үлгэр жишээч зарим алба хаагчдыг салбарын шагналаар шагнаж урамшууллаа.

Үүний дараагаар Батлан хамгаалахын сайдаар ахлуулсан ажлын хэсэг тус аймагт үйл ажиллагаа явуулж буй Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлан чиг үүрэг бүхий алба хаагчдын 150 хүүхдийн цэцэрлэгийн нээлтэд оролцсон юм. Тус цэцэрлэг нь Батлан хамгаалах яамны захиалгаар, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Зэвсэгт хүчний 340

дүгээр анги барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэж Улсын комисст хүлээлгэн өгчээ.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр тус үйл ажиллагааг нээж хэлсэн үгэндээ "Өнөөдрийн байдлаар Баян-Өлгий аймгийн Өлгий хотод 24 цэцэрлэг үйл ажиллагаа явуулдаггаас монгол хэл дээр сургуулийн өмнөх боловсрол олгодог цэцэрлэг байхгүй. Монгол орны алс баруун хязгаарт ажиллаж амьдарч байгаа тусгайлан чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагчдын хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгохдоо монгол хэлээр сургалт явуулах зайлшгүй шаардлага үүсээд байсан билээ. Энэхүү цэцэрлэг нь хүүхэд багачуудын маань сурч боловсрох нөхцлийг сайжруулах, боловсрол эзэмших боломжийг нэмэгдүүлж, ирээдүйн хөгжил цэцэглэлтийн үүд хаалгыг нээж гэдэгт итгэлтэй байна" хэмээв. Ажлын хэсэг үргэлжлүүлэн улсын тусгай хэрэгцээний газар баригдах 100 хүүхдийн цэцэрлэгийн шав тавих арга зэмнэнд оролцсон юм. Уг цэцэрлэгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн барилгачин дайчид барьж байгуулахаар бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна.

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 690,283,602

Эдгэрсэн

Нийт: 6,890,405

Нас барсан

Нийт: 662,715,311

Цахим шууданд

# Б.БАЯРМАГНАЙ: НИЙТ НУТАГ ДЭВСГЭРИЙН 0,3 ХУВЬД ХҮН АМЫН 50 ОРЧИМ ХУВЬ НЬ АЖИЛЛАЖ АМЬДАРЧ БАЙНА



Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороодын Засаг дарга, удирдлагууд оролцсон "Шинэ сэргэлтийн бодлого - Анхан шат 2023" зөвлөлдөх уулзалтыг анх удаа зохион байгуулж байна. Зөвлөлдөх уулзалтыг нээж Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ үг хэлж, "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын явц, онцлох ажлууд, улс орны нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдлын талаар танилцууллаа.

"Шинэ сэргэлтийн бодлого"-ын Боомтын сэргэлтийг эрчимжүүлснээр экспортын хэмжээ нэмэгдэж, хил гааль, тээвэр ложистикийн гацаа аажмаар арилж байна. Төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх хүрээнд авлига, хээл хахуультай тэмцэх "5Ш" ажиллагааг хэрэгжүүлж, төрийн үйл ажиллагааг ил тод нээлттэй болгоход анхаарч, төрийн мэдээллийг шилэн,

тод байршуулж эхэллээ, төрийн өмчит компаниудад шинэчлэл хийж эхэллээ, төрийн байгууллагуудад процессын дахин инженерчлэл хийж байна. Үүний үр дүнд иргэд чанартай үйлчилгээ авах ёстой юм. Үүнд зөвлөлдөх уулзалтад оролцож буй та бүхний оролцоо, хүчин чармайлт чухал гэв.

Үргэлжлүүлэн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар болон Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай нар "Хот ба хөдөөгийн сэргэлт" бодлогын хэрэгжилтийн талаар танилцууллаа.

Энэ үеэр Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай хэлсэн үгэндээ "Монгол Улсын хүн амын 50 орчим хувь нь нийт нутгийн 0,3 хувь буюу Улаанбаатар хотод төвлөрөн суурьшиж байна. Сүүлийн 20 жилийн хугацаанд гэхэд 760 гаруй мянган иргэд хөдөө орон нутгаас Улаанбаатар хот руу шилжин суурьшсан. Өнөө үед дэлхийн аль ч улс орон ард иргэдийнхээ шилжилт хөдөлгөөний асуудлыг бүрэн гүйцэд, төгс шийдвэрлэх арга замыг нээж чадаагүй байна. Манай улсын хувьд Улаанбаатар хотод төвлөрөл үүсэж буй шалтгаан нь Улаанбаатар хотын иргэд хөдөө орон нутагт амьдарч буй иргэдийг бодвол амьдралын орчин нөхцөл, боловсролын чанар, эрүүл мэндийн үйлчилгээний

# "ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, МАНЛАЙЛАЛ" СЭДЭВТ СУРГАЛТААР...



Батлан хамгаалах яам нийт ажилтан, цэргийн алба хаагчдынхаа харилцаа хандлага, ёс зүйн төлөвшилд дэмжлэг үзүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, стресс ба цагийн менежментийг удирдах талаар мэдлэг олгох зорилгоор "Хувь хүний хөгжил, манлайлал" сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Сургалтаар Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагчийн ажлын албаны дарга хурандаа Т.Мөнхбаяр, ҮБХИС-ийн

хүндэт профессор чөлөөнд байгаа хурандаа А.Гэлэгжамц, Аюулгүй байдлын дээд сургуулийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын тэнхимийн дарга С.Мандалмаа нар "Хувь хүний хөгжил, харилцаа хандлага, удирдлагын манлайлал", "Бүтээлчээр сэтгэх нь (CQ)", "Сэтгэл хөдлөлийн оюун ухаан (EQ)", "Стресс ба цагийн менежмент" сэдвийн хүрээнд тус тус яриа хийж, бие бүрэлдэхүүний сонирхсон асуултад харуулсан юм.

# "МОНГОЛ ХҮҮХДҮҮД" ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс Зэвсэгт хүчний 013, 017, 150, 345 дугаар нэгтгэл, ангийдтай хамтран "Монгол хүүхдүүд" өдөрлөгийг зохион байгууллаа.

Өдөрлөгт 1000 хүүхэд, 3000 гаруй иргэд оролцож зэвсэг, техникийн үзэсгэлэн, урлагийн энтертайнмент үзүүлбэр, цэргийн алба хаагчдын жагсаалын болон гардан тулааны үзүүлэх тоглолтыг үзэж сонирхлоо.

Мөн хүүхэд багачуудын дунд шохойн зургийн болон дугуйн уралдаан, 3х3 сагсан бөмбөгийн тэмцээнийг тус тус зохион байгуулж, өргөмжлөл, гарын бэлэг гардуулсны зэрэгцээ 10 супер азтаныг

шалгаруулсан юм.

Түүнчлэн энэ үеэр Зэвсэгт хүчний 013, 017, 150, 345 дугаар нэгтгэл, ангийн шилдэг зургаан цэргийн алба хаагчид Нийслэлийн "Шилдэг залуу" алтан медаль, дөрвөн хүүхдэд Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын алтан медалийг тус тус хүртээв.

Ташрамд дуулгахад тус өдөрлөгт "Дэлхийн зөн" олон улсын байгууллага, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Улаан загалмайн хороо, Хүүхдийн зөвлөлийн сурагчид, сайн дурын ажилтнууд ажиллаж хүүхэд хамгаалал, аюулгүй байдлыг хангах үйлчилгээг үзүүлсний зэрэгцээ өдөрлөгийн үйл ажиллагааг дэмжин "Сүү", "Алтан тариа", "Тесо" компаниуд 1000 гаруй хүүхэд гарын бэлгийг хандивласан юм.

Дэслэгч Н.УУГАНЦЭЦЭГ

# ХАМТАРСАН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАА



Ангийн 2022-2023 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөө, "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл"-ийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Хан-Уул дүүргийн цагдаагийн газартай хамтран "Архи түүний хор уршиг" сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Тус газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн цагдаагийн ахлах дэслэгч

Г.Мөнхцэцэг хэлсэн үгэндээ "судалгаанаас харахад үйлдэгдэж байгаа гэмт хэргийн ихэнх хувь нь архи, согтууруулах ундаа, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэсэн үедээ өөрийн хяналтаа алдаж гэмт хэрэг, осол зөрчилд холбогддог" гэдгийг онцолсон юм.

Ангийн зүгээс цаашид офицер, ахлагч, ажилтан албан хаагчдад "Мөрийнтэй тоглоом түүний хор уршиг, хүлээлгэх хуулийн хариуцлага", "Цэргийн албаны эсрэг гэмт хэргийн ойлголт", "Ахуйн хүрээний осол, зөрчил" сэдвээр сургалтыг тус газар болон мэргэжлийн бусад байгууллагуудтай хамтран сар бүр зохион явуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Ахмад Д.СЭРСЭНДЭМЭД



нийслэлийн есөн дүүрэг, 21 аймаг, 330 сум, 1613 баг, 204 хороодын удирдлагууд оролцлоо. Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ цар тахлын үед ачааны хүндийг үүрэлцэн, аюулыг хохирол багатай давж, энгийн амьдрал шилжин, эдийн засгаа богино хугацаанд сэргээхэд чухал хувь нэмэр оруулсанд нь шат шатны удирдлагуудад талархал илэрхийллээ.


"Алсын хараа-2050" хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны анхан шатны байгууллагын

үйлчилгээг цахим болгох зэрэг шинэчлэл хийснээр эдийн засгийн өсөлт энэ оны нэгдүгээр улирлын байдлаар 7,9 хувийн өсөлттэй гараад байна. Төсвийн орлого дутсанаар тодотгол хийдэг байсан бол анх удаа төсвийн орлого давж биелснээр тодотгол хийж байна. Төрийн анхан шатны байгууллагууд иргэддээ нээлттэй, иргэдээ сонсдог, ярилцдаг байх

хүртээмж чанар, цалин хөлсний хувьд давуу байгаатай холбоотой байна. Тухайлбал, хөдөө орон нутагт эдийн засгийн боломж хомс, боловсрол, эрүүл мэндийн чанар, хүртээмж Улаанбаатар хоттой харьцуулахад харьцангуй сул байгаагаас дээрх нөхцөл байдал үүсэж байна. Иймээс Монгол Улсын Засгийн газраас ард иргэд төрөлх нутагтаа аз жаргалтай амьдрах боломжийг бүрдүүлж, Хот, хөдөөгийн зохист харьцааг тэнцвэртэй байлгах зорилгоор "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг санаачлан улс орон даяар хэрэгжүүлж эхлээд байна. Өнгөрсөн хугацаанд бид бүхэн, олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу бүх аймаг, орон нутгийн мэдээллийг ард иргэдэд нээлттэй болголоо. Мөн түүнчлэн хөдөө орон нутагт ард иргэд ажиллаж, амьдрахад таатай хууль эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд 30 гаруй хууль, 11 тогтоолд өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Бид бүхний цаашдын зорилго бол нийт хүн амын 60 орчим хувийг хөдөө орон нутагт тархаан суурьшуулах юм" гэлээ.

Зөвлөлдөх уулзалтын үеэр үндэсний судалгааны нэгдсэн платформыг [www.sudalгаа.gov.mn](http://www.sudalгаа.gov.mn) нээлээ. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хүрээнд төр, хувийн хэвшил, олон улсын болон мэргэжлийн байгууллагуудаас хийсэн судалгааны сан үүгээр бүрдэж, олон нийтэд нээлттэй болж байна. Тус платформыг эрдэмтэн судлаачид, шийдвэр гаргагчид, оюутан сурагч, бизнес эрхлэгч хэн бүхэн ашиглах, санал сэтгэгдлээ үлдээж бусадтай хуваалцах боломжтой юм.

Ташрамд дуулгахад эл удаагийн зөвлөлтийг уулзалтын зохион байгуулалтад Батлан хамгаалах яам дэмжлэг үзүүлж оролцсон юм.



хүчин чармайлт, үүрэг оролцоо нэн чухлыг Ерөнхий сайд онцлон тэмдэглэв. Төрийн бодлого анхан, дунд шатанд амжилттай хэрэгжиж байж улс орон хөгжинө. Монгол Улсын Засгийн газар "Алсын хараа-2050" хөгжлийн бодлогын эхний арван жилийн зорилт болох "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг эрчимтэй хэрэгжүүлж байна. Энэ бодлого амжилттай хэрэгжих эсэх нь та бидний хүчин чармайлт, хамтын ажиллагаанаас шалтгаална. Алсын хараатай, нэг зорилго, нэг бодлогын төлөө санаачилгатай, оролцоотой, хариуцлагатай ажиллаж байж үр дүнд хүрнэ гэж Ерөнхий сайд хэллээ.

Зөв хандлагын өөрчлөлт төрийн анхан шатны байгууллагаас эхлэх ёстой гэдгийг Ерөнхий сайд онцоллоо.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан "Засаглал" бодлогын хүрээнд хийгдэж буй шинэчлэлийн талаар танилцууллаа. Үндсэн хуулийн өөрчлөлтийг баталж эрх мэдлийн төвлөрлийг бууруулан, бодлого хэлэлцдэг, шийдэл ярилцдаг парламент бий болох эхлэл тавигдлаа. Төрийн мэдээлүүдийг ил